



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/1395

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн нэгдсэн архивын
үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай үзүүлэх, Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэ тушаалын хавсралтад заасан Иргэний улсын бүртгэлийн лавлагааг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсээс олгосугай.

2.Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсээс улсын бүртгэлийн лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу гаргаж өгөх, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн нэгдсэн архив /С.Оюунгэрэл/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/588 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571004514

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2020 оны тушаалын хавсралт



ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЛАВЛАГААНЫ ТӨРӨЛ

1. төрсний бүртгэлийн;
2. үрчилсний бүртгэлийн;
3. овог, эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн;
4. эцэг /эх/ тогтоосны бүртгэлийн;
5. гэрлэсний бүртгэлийн;
6. гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн;
7. гэрлэлт бүртгэлгүй тухай;
8. нас барсны бүртгэлийн;
9. төрөл садангийн;
10. ХААТР -1 маягтын /2 төрөл/;
11. цахим үнэмлэхийн;
12. байнга оршин суугаа хаягийн;
13. иргэний үнэмлэх аваагүй тухай;
14. зураг баталгаажуулалт;
15. үндэсний энгийн гадаад паспортын /3 төрөл/;
16. засвар өөрчлөлтийн бүртгэлийн;
17. регистрийн дугаарын;
18. регистрийн дугаар сольсон тухай;
19. гэрлэлт сэргээсний бүртгэлийн;
20. цахим архиваас хуулбар олгох.

--- оОо ---